



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/73

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Цэргийн алба хаагчдын хөгжлийн төв байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Г.Алтанхуяг -Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн санхүү албаны дарга

Гишүүдэд: Ц.Даваасамбуу -Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Ц.Цэвээнсүрэн -Төрийн бус байгууллагын төлөөлөл


Б.Отгонжаргал - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Э.Цолмон -Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Г.Алтанхуяг/-нд даалгасугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Э.Цолмон /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД